44

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 06 сарын 02 өдөр Дугаар 186 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эрүүл мэндийн байгууллага дахь халдварын сэргийлэлт, хяналтын зохион байгуулалт"-ыг нэгдүгээр, "Эрүүл мэндийн яамны дэргэдэх халдварын сэргийлэлт хяналтыг зохицуулах чиг үүрэг бүхий зөвлөлийн бүрэлдэхүүн"-ийг хоёрдугаар, "Халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр эрүүл мэндийн байгууллагад хийгдэх үйл ажиллагааны жагсаалт"-ыг гуравдугаар, "Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварыг бүртгэх, мэдээлэх журам"-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус батлсугай.

2. Журмыг мөрдүүлж, удирдлагаар ханган хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төв, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /А.Эрдэнэтуяа/-д, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/-д, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх ажлыг уялдуулан зохицуулж, хариуцсан чиг үүргийн хүрээнд хэрэгжилтийг хангаж ажиллахыг газар, хэлтсийн дарга нарт даалгасугай.

4. Тушаал шинэчлэн батлагдсантай холбогдуулан "Эрүүл мэндийн байгууллагын халдвар хяналтын тогтолцоог бэхжүүлэх, эмнэлгээс шалтгаалсан халдвараас сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх тухай" Эрүүл мэндийн сайдын 2010 оны 165 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Н.УДВАЛ

D:\barimt\tushaal

081595

45

Эрүүл мэндийн сайдын 2014 оны 06
сарын 02 өдрийн 186 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт

## ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА ДАХЬ ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ, ХЯНАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар зохицуулагдах халдварын сэргийлэлт, хяналт (цаашид ХСХ гэх) нь эрүүл мэндийн байгууллагын ажиллагсад, үйлчлүүлэгч, тэдний гэр бүл болон бусад иргэд эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварт өртөхөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих үйл ажиллагааны хэм хэмжээ юм.

1.2. Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар (цаашид ЭТҮХХ гэх) гэдэг нь эрүүл мэндийн байгууллагад хийгдсэн эмчилгээ, үйлчилгээний явцад үйлчлүүлэгч шинээр халдвар авч халдварын шинж тэмдэг нь эмнэлэгт хэвтсэнээс хойш 24 цаг ба түүнээс хойших хугацаанд, эмнэлгээс гарсны дараах 1 сар, эрхтэн шилжүүлэн суулгах, хиймэл эд эрхтэн суулгах ажилбарын дараах 1 жил хүртэл хугацаанд илэрсэн халдвар, эрүүл мэндийн ажилтан ажил үүргээ гүйцэтгэж байх явцад халдварт өртөх тохиолдол юм.

1.3. ХСХ-ын тогтолцооны зорилго нь ЭТҮХХ-аас сэргийлэх, тохиолдлыг эрт илрүүлж хариу арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх замаар үйлчлүүлэгчдэд аюулгүй, чанартай тусламж, үйлчилгээ үзүүлэхэд оршино.

1.4. Халдварын сэргийлэлт, хяналтын тогтолцоо нь дараахь бүтэц зохион байгуулалттай байна.

1.4.1. Үндэсний түвшинд Эрүүл мэндийн яамны дэргэд халдварын сэргийлэлт хяналтыг зохицуулах чиг үүрэг бүхий зөвлөл ажиллана.

1.4.2. Халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр гарсан хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангуулах, мэргэжил арга зүйгээр хангах ЭТҮХХ-ыг тандан судлах, дүгнэлт гаргах үүргийг Халдварт өвчин судлалын үндэсний төв (цаашид ХӨСҮТ гэх) гүйцэтгэнэ. ХӨСҮТ нь ажлын албатай байх ба албаны дарга нь тус төвийн тандалт, сэргийлэлт эрхэлсэн дэд захирал байна. Ажлын албаны бүрэлдэхүүнийг ХӨСҮТ-ийн ерөнхий захирлын тушаалаар томилно.

1.4.3. Аймаг, Нийслэлд халдварын сэргийлэлт, хяналтыг удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий салбар зөвлөл ажиллана. Зөвлөл нь тухайн орон нутгийн засаг даргын тамгын газар, эрүүл мэндийн газар, мэргэжлийн хяналтын алба, төр, хувийн хэвшлийн эмнэлгийн төлөөллөөс бүрдэнэ. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Эрүүл мэндийн газрын дарга санал болгон, Аймаг, Нийслэлийн Засаг даргаар баталгаажуулна.

1.4.4. Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад халдварын сэргийлэлт, хяналтын асуудлыг хариуцаж, хэрэгжилтийг хангуулах, үйл ажиллагаанд дотоодын хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус ХСХ-ын баг ажиллах бөгөөд тухайн байгууллагын удирдлага нь багийн дарга байна. ХСХ-ын баг нь байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, эмнэлгийн тусламжийн төрлөөс хамааран 3-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байх ба эмнэлгийн тусламж үйлчилгээ, чанар аюулгүй байдал, тархвар судлал, хүний нөөц, лаборатори, сувилахуй, эм зүй, нян судлал, санхүү, аж ахуй, эмчилгээний асуудал хариуцсан тасаг нэгжийн төлөөллийг оролцуулсан бүрэлдэхүүнтэй байна.

## Хоёр. Эрүүл мэндийн яамны дэргэдэх халдварын сэргийлэлт, хяналтыг зохицуулах чиг үүрэг бүхий зөвлөлийн ажлын чиг үүрэг, эрх

2.1. ХСХ-ын бодлого, стратегийг боловсруулж, мэргэжил аргазүйн удирдлагаар ханган ажиллана.

2.2. ХСХ-ын ажлын үр дүн, холбогдох хууль тогтоомж, тушаал заавар, хөтөлбөр стандарт зэрэг эрх зүйн баримт бичгүүдийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний дүнг хэлэлцэж, шийдвэр гаргана.

2.3. ХСХ-ын тулгамдсан асуудлыг тодорхойлон Эрүүл мэндийн яамны удирдлагын зөвлөлд тайлагнах, шаардлагатай асуудлаар санал оруулна.

2.4. ХСХ-ын асуудлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх багийг томилон ажиллуулж болно.

2.5. ЭТҮХХ-ын дэгдэлт гарч нийгмийн эрүүл мэндэд ноцтой байдал үүссэн үед асуудлыг нэн даруй шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллана.

2.6. ХСХ-ын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл, судалгаа, дүгнэлтийг холбогдох мэргэжлийн байгууллагаас тогтоосон хугацаанд гаргуулан авч нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлнэ.

2.7. Тайлан, мэдээнд дүгнэлт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөөнөөр хангаж, зөрчлийг арилгуулах арга хэмжээг зохион байгуулна.

2.8. Зөвлөлийн ажлын зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хурал байна. Зөвлөлийн хурлыг гишүүдийн 75 хувиас дээш ирцийг бүрдүүлсэн тохиолдолд хүчинтэйд тооцно. Шаардлагатай тохиолдолд ЭМЯ-ны дэргэдэх бусад холбогдох мэргэжлийн салбар зөвлөлийн төлөөллийг оролцуулан хуралдааныг өргөтгөсөн хэлбэрээр хийж болно.

2.9. Зөвлөлийн хурлаар шийдвэрлэсэн асуудлыг Эрүүл мэндийн сайдад танилцуулж шийдвэр гаргуулна. Тэмдэглэлийг нарийн бичгийн дарга хөтөлж, зөвлөлийн дарга, дэд дарга нар хянаж гарын үсэг зурж, баталгаажуулна.

47

2.10.Зөвлөл нь ажлын албатай байх ба ажлын албаны үүргийг Халдварт өвчин судлалын үндэсний төв гүйцэтгэнэ.

## Гурав. Халдварын сэргийлэлт, хяналтын зөвлөлийн ажлын албаны үүрэг.

3.1. Улсын хэмжээнд ХСХ-ын чиглэлээр гарсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлнэ.

3.2. ХСХ-ын үйл ажиллагааны ойрын болон хэтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, төлөвлөгөө боловсруулахад санал өгнө.

3.3. ЭТҮХХ-ын байдалд дүн шинжилгээ хийж, эрүүл мэндийн байгууллагыг улирал тутам эргэн мэдээллээр хангах, ЭМЯ-ны дэргэдэх ХСХ-ын зөвлөлд хагас, бүтэн жилээр тайлагнаж, удирдамж чиглэл авч ажиллана.

3.4. Эрүүл мэндийн байгууллагууд, түүний ХСХ-ын салбар зөвлөл, багуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, үнэлэлт, дүгнэлт өгч авах арга хэмжээний зөвлөмж гаргаж, биелэлтийг хангуулна.

3.5. Тусламж, үйлчилгээнд шинээр нэвтэрч буй технологийн халдварын эрсдлийг судалж, шинэ багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж, бүтээгдэхүүнийг хэрэглэх зөвшөөрөл олгоход санал, дүгнэлт гаргана.

3.6. ХСХ-ын сургалт, мэдээллээр хангах, эрүүл мэндийн мэргэжилтнийг сургах, мэргэжил дээшлүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

3.7. ХСХ-ын удирдамж, заавар, гарын авлагуудыг шинэчлэн боловсруулах, хэрэгжүүлэх арга зүйгээр хангах, гадны улс орнуудын сайн туршлагыг нэвтрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.

3.8. ЭМБ-ын ХСХ-ын үйл ажиллагааг сайжруулах, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлүүлэх саналыг ЭМЯ болон ХСХ-ын зөвлөлд танилцуулна.

3.9. ЭТҮХХ-ын чиглэлээр тандалт, судалгааг холбогдох байгууллагуудтай хамтран хийж үр дүнг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

3.10. Эрүүл мэндийн байгууллагаас ажлын мэдээ тайлан судалгаа дүгнэлт гаргуулж, үнэлэлт дүгнэлт өгнө.

3.11. ХСХ-ын чиглэлээр олон улсын туршлага судлах, зөвлөх үйлчилгээг авч ажиллана.

3.12. Улс, хувийн хэвшлийн бүх шатны ЭМБ-даас шаардлагатай баримт бичиг, үйл ажиллагаатай танилцах, ажлын чиглэл, зөвлөмж өгнө.

## Дөрөв. Аймаг, нийслэлийн халдварын сэргийлэлт, хяналтын салбар, зөвлөлийн чиг үүрэг

4.1. ХСХ-ын чиглэлээр гарсан хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, биелэлтэнд хяналт тавьж үр дүнг тооцон ажиллана.

4.2. Орон нутгийн онцлогт тохирсон ХСХ-ын хөтөлбөр, төлөвлөгөөтэй ажиллана.

4.3. Харьяалах нутаг дэвсгэр дэх төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад ХСХ-ын холбоотой асуудлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулна.

4.4. Харьяалах нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй эрүүл мэндийн байгууллагын хяналт үнэлгээгээр илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаар үүрэг, даалгавар өгч хариуцлага тооцно.

4.5. Аймаг, нийслэлийн хэмжээнд бүртгэгдсэн ЭТҮХХ-ын байдалд дүн шинжилгээ хийж, улирал тутам хэлэлцэн, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэнэ.

4.6. Тайлан, мэдээнд дүгнэлт гаргаж, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, зөрчлийг арилгуулах арга хэмжээг зохицуулах, албан даалгавар гаргана.

4.7. Холбогдох мэдээ, мэдээлэл, судалгаа, дүгнэлтийг ЭМБ-аас тогтоосон хугацаанд гаргуулан авна.

4.8. Салбар зөвлөл нь ХСХ-ийн холбоотой асуудлаар мэргэжлийн байгууллагаас мэргэжил арга зүйн дэмжлэг авна.

4.9. ЭТҮХХ-аас сэргийлэх ажилд амжилт гаргасан, дэмжлэг үзүүлсэн байгууллага, хамт олон, эрүүл мэндийн ажилтнуудын үйл ажиллагаа, туршлагыг сурталчлах, урамшуулах ажлыг зохион байгуулна.

4.10. Салбар зөвлөл нь улирал тутам хуралдана. Шаардлагатай үед зөвлөлийн даргын шийдвэрээр хурлыг зарлан хуралдуулж болно. Хурлыг Зөвлөлийн дарга, түүний эзгүйд дэд дарга удирдана.

4.11. Салбар зөвлөл нь хуралдааны талаар хурлын тэмдэглэл хөтөлж, олонхийн саналаар шийдвэрлэсэн асуудлыг аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулж шийдвэр гаргуулна. Тэмдэглэлийг нарийн бичгийн дарга хөтөлж, зөвлөлийн дарга, дэд дарга нар хянаж гарын үсэг зурж баталгаажуулна.

4.12. Салбар зөвлөл нь хийсэн ажлаа хагас жил тутамд Эрүүл мэндийн сайдын дэргэдэх халдварын сэргийлэлт, хяналтыг зохицуулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл, аймаг, нийслэлийн засаг даргад ажлаа тайлагнана.

4.13. Халдварын сэргийлэлт, хяналтын үйл ажиллагаатай холбоотой санхүүгийн болон мэргэжлийн асуудлаар аймаг, нийслэлийн Засаг даргад санал оруулж шийдвэрлүүлнэ.

4.14. Салбар зөвлөл нь ажлын албатай байх ба ажлын албаны чиг үүргийг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар гүйцэтгэнэ.

## Тав. Эрүүл мэндийн байгууллага дахь ХСХ-ын алба/багийн чиг үүрэг

**5.1. Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах**

5.1.1. Халдварын сэргийлэлт, хяналтын чиглэлээр мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн биелэлтийг хангуулж, хяналт тавьж ажиллана.

5.1.2. Байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон ЭТҮХХ, ХСХ-ын хөтөлбөр, төлөвлөгөөтэй ажиллана.

5.1.3. Халдварын сэргийлэлт, хяналтад шаардагдах санхүүжилтийг орон нутгийн болон улсын төсөвт тусган шийдвэрлэнэ.

5.1.4. Эрүүл мэндийн байгууллагын түвшинд ЭТҮХХ-ын эрсдэлийг бууруулах, сэргийлэх, хянахад нэгдмэл байдлаар буюу бүх хүний оролцоог хангаж ажиллана.

5.1.5. Тусгай мэргэжлийн төв, төв эмнэлэг, БОЭТ, нэгдсэн эмнэлэг, амаржих газар, ор бүхий хувийн хэвшлийн эмнэлэг, оношилгооны төвүүд нь стандартын дагуу тархвар судлаач эмчтэй, тасаг нэгж бүрт халдвар хяналтын ажилтанг сургаж ажиллуулна.

5.1.6. Клиник, сум дундын эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд нь халдвар хяналтын ажилтантай байна.

5.1.7. ЭТҮХХ-аас сэргийлэх асуудлаар эмч, эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн байгууллагатай хамтран сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллана.

5.1.8. ЭТҮХХ-ын тандалт судалгаа хийж, халдварыг эрт илрүүлэн мэдээлж, хариу арга хэмжээ авна.

5.1.9. ЭТҮХХ-ын тохиолдлыг лабораторийн шинжилгээгээр баталгаажуулна. Онош баталгаажуулах, давтан шинжилгээ хийх зорилгоор эмнэлзүйн сорьц, нянгийн омгийг зохих нөхцөлд хадгалсан байна.

5.1.10. ЭТҮХХ-ын дэгдэлт гарсан болон халдвар гарах эрсдэл бий болсон үед хариу арга хэмжээ авахад тухайн эрүүл мэндийн байгууллагын чадамж хүрэхгүй тохиолдолд мэргэжлийн туслалцаа авч ажиллана.

5.1.11. Нянгийн тэсвэржилттэй уялдуулан нянгийн эсрэг эм, бэлдмэлийн зохистой хэрэглээг төлөвшүүлж ажиллана.

5.1.12. Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчид, тэдний ар гэрийнхэнд шаардлагатай мэдээлэл өгнө.

5.1.13. Тандалт, судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийж харъялах болон бусад тасаг нэгж, эрүүл мэндийн ажилтнуудад эргэн мэдээлнэ.

5.1.14. Үйлчлүүлэгчийн эрүүл мэнд болон лабораторийн шинжилгээний үр дүн (олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагддаг халдвар болон олон эмэнд тэсвэртэй нянгийн халдвартай зэрэг)-г цаг алдалгүй мэдээлнэ.

5.1.15. Үйлчлүүлэгчийн мэдээллийн нууцлалыг хадгална.

5.1.16. Эрүүл мэндийн ажилтныг халдварт өртөх эрсдэлээс сэргийлэх арга хэмжээг авч ажиллана.

5.1.17. Эрүүл мэндийн байгууллагад дадлага хийж байгаа оюутан, дадлагажигч эмч ХСХ-ын дэглэмийг дагаж мөрдөх ба халдвараас сэргийлэх зорилгоор эмнэлзүйн дадлагад гарахаас өмнө урьдчилан сэргийлэх шинжилгээ, дархлаажуулалтад хамрагдсан байна.

5.1.18. Эмнэлгийн багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариун цэврийн бүтээгдэхүүн, хувийн хамгаалах хувцас, хэрэгслийн тооцоог гаргаж, хангана.

5.1.19. Эрүүл мэндийн байгууллага нь олон улсад худалдаалах зөвшөөрөлтэй, улсын бүртгэлд бүртгэгдсэн, эрүүл мэндийн байгууллагад хэрэглэх зориулалт бүхий чанарын шаардлага хангасан ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодисыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу хэрэглэнэ.

5.1.20. Эмнэлгийн байр орчинд хортон шавж, мэрэгч үүрлэх, тархахаас урьдчилан сэргийлж ахуйн шавж, мэрэгч устгал, халдваргүйжүүлэлтийг жилд нэг удаа, шавж мэрэгч үүрлэсэн тохиолдол бүрд мэргэжлийн байгууллагаар устгал хийлгэнэ.

5.1.21. Халдвараас сэргийлэх дэглэмийн зөрчил, алдаа дутагдлыг бүртгэж, арилгуулах арга хэмжээг авна.

5.1.22. Халдварын сэргийлэлт, хяналтын чиглэлээр амжилт гаргасан, дэмжлэг үзүүлсэн байгууллага, тасаг, нэгж, эмнэлгийн ажилтнуудын үйл ажиллагаа, туршлагыг сурталчилж, урамшуулна.

## 5.2. Эрүүл мэндийн ажилтныг халдвараас сэргийлэх:

5.2.1. Эрүүл мэндийн ажилтны урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах, шаардлагатай тохиолдолд эмчлэх, эрүүлжүүлэх асуудлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулна.

5.2.2. Эрүүл мэндийн байгууллага нь “Ажлын байрны аюулгүй байдал, ажилтны эрүүл мэнд” хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ.

5.2.3. Олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагдах халдвараас эрүүл мэндийн ажилтнуудыг хамгаалах, уг халдвар илэрсэн тохиолдолд авах арга хэмжээний талаар сургалт, сурталчилгаа зохион байгуулж, мэдлэг дадал олгосон байна.

5.2.4. Эрүүл мэндийн ажилтныг халдвараас сэргийлэх зорилгоор дархлаажуулах ажлыг зохион байгуулж, дархлаажуулалтын талаар нэгдсэн бүртгэл судалгаатай байна.

5.2.5. Цусаар дамжих халдвартай эрүүл мэндийн ажилтны эрүүл мэндийн байдалд жилд 2 удаа хяналт тавьж, вирусийн идэвхжилийг хянаж, халдвараас сэргийлэх арга хэмжээний заавар зөвлөгөө өгнө.

5.2.6. Эрүүл мэндийн байгууллагад дадлага хийж байгаа оюутан, дадлагажигч эмч дадлага хийх хугацаанд халдварт өртөхөөс сэргийлж байгууллагын дотоод журам заавтрыг танилцуулж, мөрдүүлнэ.

5.2.7. Ажил олгогч нь эрүүл мэндийн ажилтныг ажлын байранд гарахын өмнө халдвар сэргийлэлт, хяналтын сургалтад хамруулж, мэргэжлийн эрсдэлт хүчин зүйлсийн талаар санамж, зөвлөгөө өгч, хөдөлмөрийн гэрээнд тусгасан байна.

5.2.8. Тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэргэжлийн эрсдэлт хүчин зүйлсийг судлан тогтоож, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, халдварт өртсөн байж болох тохиолдолд эрсдлийг үнэлэн, шаталсан арга хэмжээ хэрхэн авах талаарх мэдээллээр ажилтнуудыг бүрэн хангана.

5.2.9. Эрүүл мэндийн ажилтан цусаар дамжих халдварын эрсдэлд өртсөн тохиолдлыг бүртгэж сэргийлэлтийн арга хэмжээг авч ажиллана.

5.2.10. Ажилтнуудын эрүүл мэндийн талаарх мэдээллийн нууцыг хадгална.

**5.3. Үйлчлүүлэгчдийг халдварт өртөх эрсдлээс сэргийлэх:**

5.3.1. Эрүүл мэндийн байгууллага нь тухайн эмнэлгээр үйлчлүүлж, буй иргэд халдварт өртөх эрсдэлийн үнэлгээг хийж, эрсдэлээс сэргийлэх, бууруулах арга хэмжээ авч ажиллана.

5.3.2. Эрүүл мэндийн байгууллагад үйлчлүүлэгчид, тэдний ар гэрийнхэнд шаардлагатай мэдээлэл өгнө.

5.3.3. Төрөх болон мэс ажилбар хийлгэх үйлчлүүлэгчдийг өөрсдийнх нь хүсэлтээр вируст гепатит B, C, D, ХДХВ илрүүлэх шинжилгээг хийсэн байна.

5.3.4. Эрүүл мэндийн байгууллага нь халдвараас сэргийлэх дэглэмийг чанд баримтлан цэвэр орчинд, ариун багаж хэрэгслээр үйлчлүүлэгчид эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлнэ.

5.3.5. Үйлчлүүлэгч халдвар авах эрсдэлт хүчин зүйлд өртсөн тохиолдолд үйлчлүүлэгч болон түүний асран хамгаалагчид мэдэгдэж, халдвараас сэргийлэх арга хэмжээ, нарийн мэргэжлийн эмч, мэргэжилтний зөвлөгөө авна.

## Зургаа. Хүлээх хариуцлага

Холбогдох хууль, тогтоомж, энэ журмаар тогтоосон хэм хэмжээг зөрчсөн албан тушаалтанд дараах хариуцлагыг ногдуулна.

52

Эрүүл мэндийн сайдын 2014 оны 06
сарын 02 өдрийн 186 дугаар тушаалын
2 дугаар хавсралт

**Эрүүл мэндийн яамны дэргэдэх халдварын сэргийлэлт, хяналтыг зохицуулах чиг үүрэг бүхий зөвлөлийн бүрэлдэхүүн**

| | |
|---|---|
| Зөвлөлийн дарга: | Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга |
| Дэд дарга: | Эрүүл мэндийн яамны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга |
| Нарийн бичгийн дарга: | Эрүүл мэндийн яамны эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын сэргийлэлт, хяналтын чиг үүрэг хариуцсан мэргэжилтэн |
| Гишүүд: | Эрүүл мэндийн яамны эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга |
| | Эрүүл мэндийн яамны санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга |
| | ХӨСҮТ-ийн ерөнхий захирал |
| | Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дарга |
| | Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн дарга |
| | Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн дарга |
| | Эрүүл мэндийн яамны дэргэдэх эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын сэргийлэлт, хяналтын ерөнхий мэргэжилтэн |

Эрүүл мэндийн сайдын 2014 оны 06
сарын 02 өдрийн 186 дугаар тушаалын
3 дугаар хавсралт

## Халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр эрүүл мэндийн байгууллагад хийгдэх үйл ажиллагааны жагсаалт

| № | Чиглэл | Өрхийн ЭМТ | Сум, тосгоны ЭМТ | Сум дундын эмнэлэг | Амаржих газар | Аймаг, дүүргийн НЭ, ЭМН, төв | Сувилал | Түргэн тусламжийн төв, тасаг | БОЭТ | Төв эмнэлэг | Тусгай мэргэжлийн төв | Ор той хувийн хэвшлийн эмнэлэг, оношилгооны төв | Клиник, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага: Мэс, засал, шүд, эмэгтэйчүүд түүнтэй адилтгах үйлчилгээтэй | Клиник, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага: Бусад | Эмчилгээний гоо сайхан |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Эмнэлгийн тусламж үйлчилгээний халдварын эрсдлийг тогтоосон байх | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ |
| 2 | ХСХ-ын алба, багтай, үйл ажиллагаа нь тогтмолжсон байх | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ |
| 3 | ХСХ-ын асуудал хариуцсан тархвар судлаач эмчтэй байх | | | | √ | √ | | √ | √ | √ | √ | √ | | | |
| 4 | ХСХ-ын асуудал хариуцсан халдвар хяналтын ажилтантай байх | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ |
| 5 | Нянгийн эсрэг эмэнд мэдрэг байдлыг тодорхойлох шинжилгээ хийдэг байх | | | | √ | √ | | | √ | √ | √ | √ | | | |
| 6 | Нянгийн эсрэг эмийн хэрэглээний байдлыг судалж, хянадаг байх | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | |
| 7 | Нян судлалын лаборатори нь чанарын гадаад хяналтад хамрагддаг байх | | | | √ | √ | | | √ | √ | √ | √ | | | |
| 8 | ЭТҮХХ-ын үүсгэгчийн тандалтыг хийдэг байх | | | | √ | √ | | | √ | √ | √ | √ | | | |
| 9 | ЭТҮХХ-ыг илрүүлэх тандалтыг хийж мэдээлдэг байх | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ |
| 10 | Цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг зааврын дагуу хийдэг байх | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ |
| 11 | Ариутгалын тасаг, хэсэгтэй, эсвэл гэрээгээр гүйцэтгүүлдэг байх | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ |



53

| | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 12 | Ариутгалын чанарт дотоод хяналт тавьдаг, хими, физик, биологийн хяналт тавьдаг байх | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ |
| 13 | Нэг удаагийн хэрэгслийг давтан хэрэглэдэггүй байх | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ |
| 14 | Үйлчлүүлэгчдэд ЭТҮХХ-аас сэргийлэх мэдээлэл өгдөг байх | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | |
| 15 | ЭМА-ыг халдвараас сэргийлэх, хянах үйл ажиллагаанд оролцуулдаг байх | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ |
| 16 | Тусгаарлах өрөөтэй, сэжигтэй үйлчлүүлэгчийг тусгаарладаг байх | √ | √ | √ | √ | √ | √ | | √ | √ | √ | √ | √ | √ | |
| 17 | ЭМА-ын эрүүл мэндийн байдалд хяналт тавьж үзлэг, шинжилгээнд хамруулдаг байх | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ |
| 18 | ЭМА-ыг халдварт өртөхөөс сэргийлэх арга хэмжээ авдаг байх | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ |
| 19 | ЭМА бүрийг дараах заавар удирдамжаар хангасан байх | | | | | | | | | | | | | | |
| | Гар угаах, халдваргүйжүүлэх | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ |
| | Эмнэлэгт хэрэглэж байгаа ариутгал, халдваргүйтгэлийн бодисыг найруулах, хэрэглэх | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ |
| | Хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл хэрэглэх | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ |
| | Хурц үзүүр, иртэй багаж хэрэгсэлтэй зөв харьцах | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ |
| | Цусаар дамжих халдвараас сэргийлэх | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ |
| | Багаж хэрэгслийг халдваргүйтгэх, угаах | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ |
| 20 | Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэй ариутгал, халдваргүйтгэлийн бодисыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу хэрэглэдэг байх | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ |
| 21 | Халдварын эрсдэл өндөртэй ажилбаруудыг хянах хуудсаар шалгадаг байх | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ | √ |



54

Эрүүл мэндийн сайдын 2014 оны 06
сарын 02 өдрийн 186 дугаар тушаалын
4 дүгээр хавсралт

# ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ХАЛДВАРЫГ БҮРТГЭХ, МЭДЭЭЛЭХ ЖУРАМ

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварыг (ЭТҮХХ)-ыг бүртгэх мэдээлэх үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. ЭТҮХХ-ыг **сэжигтэй** болон **батлагдсан** гэсэн 2 тохиолдлоор бүртгэнэ.

1.3. Эмнэлзүй, хамшинжээр оношилсон тохиолдлыг "Сэжигтэй тохиолдол"-оор, тархвар судлалын судалгаа, эмнэлзүй, лабораториор оношилсон тохиолдлыг "Батлагдсан тохиолдол" –оор бүртгэж мэдээлнэ.

1.4. "Халдварт өвчин хам шинж сэжигтэй тохиолдлыг мэдээлэх хуудас"-ыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагад хэтлөнө.

1.5. ЭТҮХХ-ын тохиолдлын тандалт, оношилгоонд энэ хавсралтын 3 дахь хэсэгт заасан ангилал, тодорхойлолт, лабораторийн шалгуурыг ашиглана.

1.6. ЭТҮХХ бүртгэгдсэн эрүүл мэндийн байгууллага нь халдварын шалтгааныг тогтоох, эрсдэлт хүчин зүйлийг арилгах, халдвар тархалтыг бууруулахад чиглэгдсэн хариу арга хэмжээг шуурхай авна.

1.7. Хариу арга хэмжээ авах чадавхи (хүний нөөц, тусламж, үйлчилгээ, оношлуур г.м) хүрэлцэхгүй тохиолдолд дараагийн шатны эрүүл мэндийн байгууллагаас мэргэжлийн туслалцаа дэмжлэг авч ажиллана.

## Хоёр. ЭТҮХХ-ыг илрүүлэх тандалт хийх

2.1. Эрүүл мэндийн байгууллагууд нь ЭТҮХХ, түүнд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэх тандалтыг (идэвхигүй, идэвхитэй) зохион байгуулна.

2.2. Үйлчлүүлэгчдийн дунд ЭТҮХХ-ыг илрүүлэх тандалтыг хийнэ.

| | |
|---|---|
| **Үйлчлүүлэгчдийн дунд:** | - Түгээмэл тохиолддог ЭТҮХХ-ыг илрүүлэх тандалтыг Хүснэгт 1, 2, 3, 4, 5, 6-д заагдсан халдварыг шинж тэмдгээр тандах хуудсын дагуу өдөр бүр хийх<br>- Эмнэлэгт хийгдэж буй халдварын эрсдэл өндөр ажилбаруудтай холбоотой халдварын шинж илэрсэн тохиолдол<br>- Эмнэлгийн тусламж авснаас хойш 72 цагийн дараа өөрт өмнө байгаагүй ямар нэгэн халдварын шинж тэмдэг илэрсэн тохиолдол (нууц үедээ байсан халдварыг тооцохгүй),<br>- Хэд хэдэн үйлчлүүлэгчид халдварын |

| | |
|---|---|
| | ижил шинж тэмдэг илэрсэн, шалтгаан нь тодорхойгүй халууралттай үйлчлүүлэгч байгаа эсэх<br>- Олон эмэнд тэсвэртэй нянгийн халдвартай үйлчлүүлэгчийг илрүүлэх<br>- Цочмог халдварт өвчнөөр үйлчлүүлэгч өвдсөн эсэх,<br>- Халдварын эрсдэл өндөртэй тасагт (мэс засал, сэхээн амьдруулах, төрөх, нярайн тасаг) хэвтэн эмчлүүлэгчдийн дунд эмчлэгдэхгүй байгаа өвчин эмгэг байгаа эсэхийг илрүүлэх<br>- Цочмог B, C, D вируст гепатитын халдвартай үйлчлүүлэгчдийн дунд нууц үеийн хугацаанд эмнэлгийн тусламж авсан эсэх<br>- Нярай үедээ (28 хоног дотор) эргэж хэвтсэн, өвчний учир ЭМБ-аар үйлчлүүлж байгаа нярай хүүхдийн дунд халдварын шинж байгаа эсэх<br>- Төрөлт, мэс ажилбарын дараа эргэж хэвтсэн, өвчний учир ЭМБ-аар үйлчлүүлж байгаа үйлчлүүлэгчдийн дунд ЭТҮХХ-ыг илрүүлэх тандалтыг зохион байгуулна. |

2.3. ЭТҮХХ-ыг үүсгэж буй үүсгэгч, түүний эмэнд тэсвэржилтийн байдлыг тандана.

2.4. Гарын эрүүл ахуй сахилт, багаж, хэрэгслийн ариутгал, халдваргүйтгэл, орчны цэвэрлэгээ, нянгийн эсрэг эмийн хэрэглээ, хурц үзүүр иртэй багаж хэрэгсэлд өртөлт, ӨДС-ийн арга хэмжээ зэрэг халдвараас сэргийлэх үйл ажиллагаанд тандалт, хяналтыг зохион байгуулна.

## Гурав. ЭТҮХХ-ыг бүртгэх, мэдээлэх

**Яаралтай мэдээ**

3.1. Үжил халдвар, мэс заслын дараах шархны халдвар, менингит, уушгины хатгалгаа, ховор тохиолдох халдваруудын 1 тохиолдол, 2 буюу түүнээс дээш үйлчлүүлэгчдийн дунд илэрсэн ижил шинж тэмдэг бүхий халдварын сэжигтэй тохиолдол, ЭТҮХХ-ын сэжигтэй тохиолдлоор нас баралт бүртгэгдсэн бол онош батлагдахыг хүлээхгүйгээр дараагийн шатны эрүүл мэндийн байгууллагад 24 цагийн дотор яаралтай мэдээлнэ.

3.2. Мэдээлэл нь “ЭТҮХХ-ын сэжигтэй болон батлагдсан тохиолдлыг мэдээлэх урсгал”-ын дагуу:

- Нийслэлд өрхийн эрүүл мэндийн төв нь дүүргийн эрүүл мэндийн нэгдэлд, дүүргийн эрүүл мэндийн нэгдэл, нэгдсэн эмнэлэг, амаржих газар, улс, хувийн хэвшлийн эмнэлгүүд нийслэлийн эрүүл мэндийн газарт;
- Орон нутагт бүсийн оношлогоо эмчилгээний төв, нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн эмнэлгүүд аймгийн эрүүл мэндийн газарт мэдээлнэ.

3.3. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэжлийн чиглэлээр тусламж, үйлчилгээ үзүүлж буй хувийн хэвшлийн эмнэлгүүд ХӨСҮТ-ийн Тандалт, судалгааны албанд **www.nccd.gov.mn/ewar/** вэб хаягаар болон утсаар “Халдварт өвчин хамшинж сэжигтэй тохиолдлыг мэдээлэх хуудас” АМ-2 маягтын дагуу мэдээлнэ.

3.4. ЭТҮХХ-ын сэжигтэй тохиолдлыг мэдээлэхэд “Халдварт өвчин хамшинж сэжигтэй тохиолдлыг мэдээлэх хуудас” АМ-2 маягтын I хэсгийг, батлагдсан тохиолдлыг I, II хэсгийг асуумжийн дагуу бөглөсөн байна.

3.5. ХӨСҮТ нь яаралтай мэдээгээр ирсэн ЭТҮХХ-ын сэжигтэй тохиолдлын мэдээг ЭМЯ-д яаралтай мэдээлнэ.

**Долоо хоногийн мэдээ**

3.6. Эрүүл мэндийн байгууллага нь ЭТҮХХ-ын сэжигтэй болон батлагдсан тохиолдол бүрийг бүртгэнэ.

3.7. Долоо хоногийн мэдээнд эпидемиологийн хуанлигаар өмнөх долоо хоногийн ням гаригаас дараа долоо хоногийн ням гариг хүртэлх мэдээг хамруулна.

3.8. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, хувийн хэвшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, бүсийн оношлогооо, эмчилгээний төв, амаржих газрууд ЭТҮХХ-ын сэжигтэй болон батлагдсан тохиолдлуудын мэдээг долоо хоног бүр нэгтгэж харьяа аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт даваа гаригт “Халдварт өвчин хамшинж сэжигтэй тохиолдлыг мэдээлэх хуудас”-аар мэдээлнэ.

3.9. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэжлийн чиглэлээр тусламж, үйлчилгээ үзүүлж буй хувийн хэвшлийн эмнэлгүүдээс ирүүлсэн ЭТҮХХ-ын сэжигтэй болон онош батлагдсан тохиолдлын мэдээг долоо хоногоор нэгтгэж мягмар гаригт цахим хэлбэрээр ХӨСҮТ-ийн Тандалт судалгааны албаны **www.nccd.gov.mn/ewar/** вэб хаяг руу илгээнэ.

3.10. ХӨСҮТ-ийн Тандалт судалгааны алба нь ЭМБ-аас ирүүлсэн бүх мэдээг үндсэн баазад нэгтгэж долоо хоногийн пүрэв гариг бүр эргэн мэдээлнэ.

**Сарын мэдээ**

3.11. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд ЭТҮХХ-ын батлагдсан тохиолдлуудыг сар бүр нэгтгэж “Халдварт өвчин, хамшинж, сэжигтэй тохиолдлыг мэдээлэх хуудас” –аар мэдээллийн урсгалын дагуу мэдээлнэ.

3.12. Сарын мэдээнд тухайн сарын 1-ний өдрөөс эхлэн дараагийн сарын 1-ний өдөр хүртэлх халдварын мэдээг хамруулна.

3.13. ЭТҮХХ-ын батлагдсан тохиолдлын оношийг “Өвчний олон улсын 10 дугаар ангилал”-ын дагуу мэдээлнэ.

3.14. ЭТҮХХ-ын бүртгэл, мэдээллийг бүх шатны бүртгэл мэдээллийн албанд нэгтгэнэ.

3.15. Эрүүл мэндийн байгууллагууд нь ЭТҮХХ-ын тандалт хийж халдварын сэжигтэй болон батлагдсан тохиолдлыг энэхүү хавсралтын “Хүснэгт 7, 8“ дахь загварын дагуу сар бүр ХӨСҮТ-ийн тандалт, судалгааны албанд

цаасаар буюу цахим хэлбэрээр мэдээлнэ. Тус мэдээг сар бүр нэгтгэн гаргаж аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт дараа сарын 5-ны, ХӨСҮТ-д 10-ны өдрийн дотор өгнө.

3.16. Тус журмын "Хүснэгт-9, 10" –ын дагуу дундаж хатгалт, эмнэлгийн ажилтны эрсдэлт хүчин зүйлд өртөлтийн мэдээг гаргаж сар бүр аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт дараа сарын 5-ны, ХӨСҮТ-д 10-ны өдрийн дотор мэдээлнэ.

3.17. ЭТҮХХ-ын сэжигтэй болон батлагдсан тохиолдолд авсан хариу арга хэмжээний тайланг сар бүр дараагийн шатанд хүргүүлж байна.

**Улирал, жилийн мэдээ**

3.18. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд ЭТҮХХ-ын 7 хоног, сар бүр ирүүлсэн сэжигтэй болон батлагдсан тохиолдлын мэдээг өссөн дүнгээр гаргаж улирал, жилийн тайланд тусгана.

3.19. Тус журмын хавсралт "Хүснэгт 11, 12, 13"-д заасан загварын дагуу эмнэлгийн ажилтны дундах цусаар дамжих халдварын байдал, ариутгал, халдваргүйтгэлд хэрэглэж байгаа тоног, төхөөрөмж, бодисын судалгааг жил бүр гаргаж аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт дараа жилийн 5-ны, ХӨСҮТ-д 10-ны өдрийн дотор ирүүлнэ.

3.20. ХӨСҮТ нь улирал тутам ЭТҮХХ-ын сэжигтэй болон батлагдсан тохиолдлын мэдээг нэгтгэн дүн шинжилгээ хийж дараа сарын 15-ны дотор, жилийн мэдээг дараа жилийн 2 дугаар сард багтааж эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагад эргэн мэдээлнэ.

3.21. ХӨСҮТ нь ЭТҮХХ-ын улсын хэмжээний мэдээллийн санг бүрдүүлж, жил бүр нэмэлт хийнэ.

3.22. Эрүүл мэндийн байгууллагууд нь жилийн хугацаанд ХСХ-ыг сайжруулах чиглэлээр хийсэн ажлын тайланг мэдээллийн урсгалын дагуу дараагийн шатны эрүүл мэндийн байгууллагад жилд 1 удаа тайлагнана.

## ЭТҮХХ-ын сэжигтэй болон батлагдсан тохиолдлыг мэдээлэх урсгал






59

60

## Гурав. Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын ангилал, тодорхойлолт, лабораторийн шалгуур

| Халдварын ангилал | Тохиолдлын тодорхойлолт | Лабораторийн шалгуур |
|---|---|---|
| **Мэс ажилбарын дараах шархны халдвар** | Мэс ажилбар хийлгэснээс хойш 30 хоног дотор арьс, арьсан доорх, булчингийн болон гүний эдэд дараах шинж тэмдгээс нэг нь илэрсэн бол:<br>1. Шархнаас эсвэл гуурсаар идээт шүүрэл ялгарна.<br>2. Шарх өөрөө задарсан.<br>3. 38 хэм ба түүнээс дээш халуурна.<br>4. Шархны орчмоор өвдөнө.<br>5. Шархны орчмоор эмзэглэлтэй байна.<br>6. Эмч шархыг нээсэн.<br>7. Хагалгааны явцад идээт голомт (буглаа) эсвэл халдварын шинж тэмдэг илэрсэн. | Шархны арчдас, шүүрэлд нян судлалын шинжилгээгээр бичил биетэн илрэх |
| **Цусны халдварууд (үжил)** | Дараах шинж тэмдгээс аль нэг шинж илэрсэн.<br>• Шалтгаангүйгээр 38 хэм ба түүнээс дээш халуурах.<br>• Даралт унана (систолийн даралт <90 мм рт.ст.)<br>• Шээсний гарц хэмжээ багасна (>20 мл/цаг).<br>• Судасны цохилт түргэснэ(>90 удаа/мин).<br>• Арьсны өнгө өөрчлөгдөж, зэвхий саарал болно.<br>**1 хүртэл насны хүүхдэд дараах шинжүүдээс аль нэг нь илрэх:**<br>• Шалтгаангүйгээр 38 хэм ба түүнээс дээш халуурах, эсвэл 37 хэмээс бууна.<br>• Апноэ эсвэл брадикарди илэрнэ.<br>• Арьс эрээнтэж, саарaлтана.<br>• Хоол, хөхөндөө дургүйцнэ<br>• Нойрмог, унтаа болно. | Тодорхой байрлалтай халдвар илрээгүй байхад:<br>• Цусанд эмгэгтөрөгч нян ургана.<br>**Эсвэл**<br>• Цусанд 2 удаагийн нян судлалын шинжилгээгээр арьсны хэвийн бичил биетэн ургах<br>• Нян судлалын шинжилгээ хийгдээгүй, эмч үжлийн заалтаар нянгийн эсрэг эмчилгээ хийсний дараа, сорьц буруу авсан, шинжилгээний алдаа зэргээс шинжилгээнд нян илрэхгүй байж болно. |
| **Бөөр, шээсний замын халдварууд** | **А. Шинж тэмдэг бүхий халдварууд:**<br>Дараах шинжүүдээс илэрнэ.<br>• 38 хэм ба түүнээс дээш халуурах.<br>• Дизурийн шинж тод илэрнэ.<br>• Ууц, нуруу, бүсэлхий, давсагны орчмоор өвдөнө.<br>• Ойр, ойрхон шээс хүрнэ.<br>• Шээх үед шээсний сүвээр хорсож өвдөнө.<br>**Б. Шинж тэмдэггүй бактериурия:** Шинж тэмдэг илрэхгүй.<br>1. Нян судлалын шинжилгээ авахаас өмнө 7 хоногийн турш давсагны шээлгүүртэй байсан **эсвэл**<br>2. Нян судлалын шинжилгээ авахаас өмнө 7 хоногийн турш давсагны шээлгүүргүй байсан. | Дараах нөхцлийн аль нэг нь илэрнэ.<br>• Шээсэнд 2-с доошгүй төрлийн нян $\geq 10^5$ КОЕ/ мл хэмжээтэй ургах **эсвэл**<br>• 2 удаагийн шээсний шинжилгээнд нэг төрлийн эмгэгтөрөгч нян $\geq 10^2$ КОЕ/ мл илрэх<br>• Нянгийн эсрэг эмчилгээ хийгдэж байхад $<10^5$ КОЕ/мл хэмжээтэй эмгэгтөрөгч нян илрэх |

61

| Халдварын ангилал | Тохиолдлын тодорхойлолт | Лабораторийн шалгуур |
|---|---|---|
